ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 3

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл 3
1.2. Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил: 3
1.3. Төслийн хүчин чадал, ажиллах горим 4
1.4.Шохой боловсруулах үйлдвэрийн технологи 5

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 7

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 9

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 11

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 13
4.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 14
4.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 14
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 14
4.5. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө 15
4.6. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр 16
4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө 17
4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөл өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь 18
4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 19

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Унд ахуйн усны хэрэглээ....4
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал....13
Хүснэгт 3.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө....14
Хүснэгт 4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө....14
Хүснэгт 5. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн зардал, төгрөг....15
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал....16
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал....17
Хүснэгт 8. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал....18
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө....19
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн товчоо....20

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил....4
Зураг 2. Шохойн чулуу бутлах дамжлага....5
Зураг 3. Эргэх зуухны бүтэц....6
Зураг 4. Шохойн үйлдвэрийн фото зураг....6

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Тэвш нуур” шохойн чулууны ордыг түшиглэн байгуулж буй “Шохой боловсруулах үйлдвэр”
Төсөл хэрэгжүүлэгч:	ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 1411008093 Улсын регистрийн дугаар: 3867722 Улсад бүртгүүлсэн: 2014.11.12
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 2-р хороо, Улаанбаатар өртөө, 2 давхарт 1-2 тоот: Утас: 245908, 99079735
Бүтээгдэхүүн:	85.24 хувийн CaO -ын дундаж агуулгатай, II зэргийн MNS 347:2002 стандартыг хангасан шохой
Хүчин чадал	30 мян.тонн/жилд
Нийт хөрөнгө оруулалт	14.63 тэрбум төгрөг
Ажиллах хүч	57
Ажиллах хугацаа	Шохой боловсруулах үйлдвэр нь жилд 12 сарын турш 300 хоног, 12 цагийн үргэлжлэлтэй, хоногт 2 ээлжээр ажиллана.

1.2.Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 140.0 км-т, Баянцагаан сумын төвөөс зүүн хойт зүгт 30.0 км-т, төмөр замын Мааньт өртөөнөөс баруун урд зүгт 40.0 км зайд L-48-47 хавтгайд “Тэвш нуур” шохойн чулууны ордын MV-014799 тоот тусгай зөвшөөрлийн талбай дотор 1.5 га талбайд оршино.

Шохой боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн шийдлийг “Э-Транс” ХХК-ийн уурхайгаас хангах болно.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.3. Төслийн хүчин чадал, ажиллах горим

Хүчин чадал: Бутлалт-шигшилтийн хэсгийн хүчин чадал нь жилд 51.0 мян.тн, харин эргэх зуухаар шохой үйлдвэрлэх үйлдвэрийн хүчин чадал нь жилд 30.0 мян.тн байхаар төлөвлөн, нийт 10 жилийн хугацаанд үйлдвэрийг ажиллана.

Ажиллах горим: “Шохой боловсруулах үйлдвэр нь жилд 12 сарын турш 300 хоног, 12 цагийн үргэлжлэлтэй, хоногт 2 ээлжээр ажиллана.

Усан хангамж:

Усыг технологийн болон ахуйн хэрэглээнд хэрэглэх ба уурхайн дэргэдэх өөрийн худгаас чайнад татаж дүүргэн, түгээх журмаар ашиглана. Төслийн хүрээнд нийт 57 хүн ажиллах боловч тэдгээр нь 2 ээлжээр ажиллана. Төслийн талбай дээр хоногт 38 хүн ажиллаж байхаар төлөвлөсөн байна. Хоногт 1 хүнд дунджаар 150 л ус /БОНХАЖСайдын А/301р тушаалын 12-р хавсралтын дагуу/ хэрэглэхээр тооцлоо.

Хүснэгт 1. Унд ахуйн усны хэрэглээ


№	Үзүүлэлт	Норм	Хэмжээ	Хоног	Хоногийн усны хэрэглээ, м^3	Жилийн усны хэрэглээ, м^3
1	Унд ахуйн болон хэрэглээний ус	150 л/хоног	38 хүн	300	5.7	1710
2	Технологийн ус	1м^3/хоног	-	200	1	200
3	Гал унтраах усыг нөөцлөх	3м^3/хоног			3	-
Нийт дүн					9.7	1910

Үйлдвэрийн технологид үйлдвэрийн температурыг хянах зориулалтаар жилд 200м^3 ус хэрэглэдэг.

1.4.Шохой боловсруулах үйлдвэрийн технологи

Шохойн чулууны үйлдвэр нь шохойн чулууг хоёр шатны бутлалт, шигшилт, шатаах зуухаар оруулж өндөр чанарын шохой үйлдвэрлэж зах зээлд нийлүүлнэ.


Шохой бутлах. Шохойн чулууг бутлахад эхний шатанд 500х750 хацарт бутлуураар бутлаад, 2 дахь шатны бутлалтад 2 ширхэг 250х1200 хацарт бутлуураар буталж, ангилагч шигшүүрээр <8мм, 8-30мм гэсэн 2 ширхэглэлээр ангилан ялгаж, 8-30 мм-ийг нь шатаагаад <8мм-аар нь тээрэмдэж эрдэс хийхээр төлөвлөжээ.



Зураг 2. Шохойн чулуу бутлах дамжлага

Шохойн чулуу шатаах хэсэг: Шохойн чулууг урьдчилан халаагчгүйгээр шатаах зууханд өгнө. Буталж ангилсан шохойн чулууг эргэх зууханд (Ф 2.5*50м) шатааж шохой гаргаж авна. Урьдчилан халаагчгүйгээр 1 ба 2 үе шаттай тоос шүүгчээр шүүсний дараа

шүүгдсэн хольцыг шурган дамжуулагчаар эргүүлж эргэх зуух руу ачаалагдан 1200°C-1400°C температурт шатаж шохой үүсэх процесс явагдана. Үйлдвэрлэн гарах бүтээгдэхүүний чанар тогтмол, идэвхийн хувь нь хангалттай өндөр байна. Шохой шатаах эргэх зуух нь шатаалтын процесс явуулах бүрэн автоматжуулж механикжуулсан тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.



Зураг 3. Эргэх зуухны бүтэц



Зураг 4. Шохойн үйлдвэрийн фото зураг

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгал: Ордын район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн 1, 2-р сард -20°С- 38°С хамгийн дулаан нь 7, 8 сард +17,7°С +32°С хүрнэ. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 230 мм, зуны саруудад дунджаар 10 мм, харин өвөлдөө 0.3-8.4 мм багасаж хур тунадас унадаг. Анхны цас 9 сарын дундуур, сүүлчийн цас 5 сарын дундуур орно. Өвөл хөрсний хөлдөлт 2.4-3.4 м гүн хөлдөлт болдог. Ордын районы хэсэгт олон жилийн мөнх цэвдэгшилд ажиглагдаагүй болно. Улирлын хөлдөлт 2.0-3.2 м болно.

Газар зүйн байдал: Тэвш нуурын талбай нь Хэнтийн уулархаг мужийн өвөр тал, төв монголын хээр талын хойд захыг хамарсан завсрын бүсэд байрлана. Энэ бүс нутагт элэгдэл - тэгшрэлийн үйл ажиллагаа хүчтэй явагдсанаас өндөр уул нурууд байхгүй зөвхөн дундлаг өндөртэй дов толгод, өргөн хөндийнүүдээс тогтсон гадаргатай.

Газрын гадарга нь ерөнхийдөө 1440.0-1600.0 м өндөрлөгтэй, дунджаар 1500 м өндөртэй. Дов толгод хоорондын хөндийнүүд дунджаар 1470.0 м өндөртэй ордын баруун талд зогсоолын гол овоо нь 1624.6 м өндөртэй ноёлох өндөрт орно.

Ус зүй: Тал хээрийн бүс учраас байнгын урсгалтай гол, горхи байхгүй. Хаврын цас хайлах үе мөн зуны аадар бороонy үед хуурай сайр, жалгуудаар ус урсаж түр зуурын урсгал ус буй болохын зэрэгцээ нуур, тойрмууд усаар сэлбэгдэнэ.

Бороо ихтэй зуны улиралд жижиг булгуудын ундарга сэргэн задгайрч урсгал үүсгэдэг. Мөн гар худгуудын усны түвшин дээшилж ундарга нэмэгдэнэ.

Харин сүүлийн жилүүдэд цаг агаар хуурайс ч, өвлийн улиралд цас бага унах, зунд нь бороо бага ордог болсноос ил задгай нуур, цөөрмүүд хатаж, гар худгуудын ус ширгэж хэрэгцээнээс гарсан тохиолдол цөөн бус байна.

Хөндий, өргөн жалгуудад нэвтэрсэн худгийн усны найрлагад хужир шүү ихтэй учраас ахуйн хэрэглээнд тохиромж муутай.

Уурхай өөрийн талбайдаа худаг гаргасан бөгөөд ахуйн хэрэгцээнийхээ усаа худгаасаа хангана.

Зам харилцаа: Ордоос зүүн зүгт 30.0 км-ийн зайд Улаанбаатар-Замын Үүдийн төмөр зам болон хатуу хучилттай авто зам дайран өнгөрнө. Мөн Зуун мод хот, төмөр замын Мааньт өртөө, Баянцагаан сумын төв зэрэг суурин газруудтай гадаргын нягтрал сайтай шороон замаар холбогдсон.

Жилийн аль ч улиралд авто машинаар зорчих, ачаа тээвэрлэх боломжтой. Ховроор тохиолдох цас их орсон өвлийн улиралд хүндрэл гарах тохиолдол байж болно.

Дэд бүтэц: “Э-Транс” ХХК нь өөрийн эзэмшлийн “Тэвш нуур” нэртэй шохойн чулууны уурхай нь Төв аймгийн Баянцагаан – Багахангайн чиглэлийн цахилгаан дамжуулах 35.0 кВ –ын агаарын шугамаас салаалж 1.2 км-т орших шохойн чулууны уурхай хүртэл агаарын шугам татаж эрчим хүчээр хангасан байна. Мөн ажилчдын тосгон, засварын цех зэргийг барьж байгуулжээ.

Усан хангамжийн хувьд өөрийн талбайдаа 3.1 л/с-ийн ундаргатай 2 худаг гарган унд ахуйн хэрэгцээгээ хангаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Газрын гадарга

Төслийн талбай нь Төв аймгийн Баянцагаан сумын нутагт MV-014799 тоот тусгай зөвшөөрлийн талбай дотор 1.5 га талбайг эзлэн оршино. Үүнд шохойн үйлдвэр, машины зогсоол, оффис байрлана. Энэ талбай нь үйлдвэрийн барилга, байгууламжуудад дарагдах, авто тээврийн хэрэгслийн зогсоол, хөдөлгөөнд эвдэрч талхлагдах байдлаар нөлөөлөл үзүүлнэ.

Агаарын чанарт нөлөөлөх байдал

“Баянцемент” ХХК нь 2024 оны 8 дугаар сарын 22 өдөр кемпийн гадна талбай болон үйлдвэрийн гадна ЦУОШГ-ын БОХЗТЛ-оор дуу, чимээний 20 минутын хэмжилт хийлгэсэн. Шинжилгээний дүнд хүхэрлэг хий (0.0016, 0.0013мг/м^3), азотын давхар исэл (0.0033, 0.0018мг/м^3) нь бага түвшинд байсан. Нийт тоосны хэмжээ нь кемп дээр 0.119 мг/м^3, үйлдвэрийн орчимд 0.200 мг/м^3, дуу чимээ нь 47, 51 ДБА байна. Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 хүлцэх агууламжийг даваагүй байна.

“Тэвш нуур” шохойн чулууны ордыг түшиглэн байгуулж буй, “Шохой боловсруулах үйлдвэр” төслийг хэрэгжүүлснээр хүнд даацын автомашины хөдөлгөөн, шохой шатаах зуух, үйлдвэр барих явцад эвдэгдсэн ургамажилтгүй болсон талбай, автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал агаарыг бохирдуулагч бодисын эх үүсвэр болно.

Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдал

Баянцагаан сум орчмын хөрс нь “нунтаг карбонатлаг хар хүрэн” хөрсний ангилалд багтана.

Шохойн үйлдвэр орчмын 0.5 га талбайн барилга байгууламжинд дарагдаж, нийт 3.1 га талбайн хөрс нь үйлдвэр баригдах, автозамын хөдөлгөөн гэх мэтчилэн нөлөөлөлд өртсөн. Мөн хөрс ахуйн хаягдал хог хаягдлаар орчин бохирдох, шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.

Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал

Нийт 3,1 га орчимд ямар нэгэн нөлөөлөл үзүүлж үйлдвэрийн барилга, зам, талбайд дарагджээ. Зам харгуй, ахуйн бохирдол үүсч ургамал бохирдох, талхлагдах зэргээр ургамалжилтын зүйлийн баялаг буурах болзошгүй. Үйлдвэрийн зуухнаас ялгарах тоос, хөө нь ургамал дээр буух үед ургамлын фотосинтез буюу хоололт буурч

улмаар үхэх, ургамлын бүлгэмдлийн зүйлийн баялаг буурах, өсөл удаашрах, хог ургамлын тархац нэмэгдэх зэргээр нөлөөлөл үзүүлж боломжтой. Иймд тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч байх шаардлагатай юм.

Газрын доорхи усны нөөцөд нөлөөлөх байдал

Усны хэрэгцээг Э-Транс ХХК-ийн худгийн уснаас хангах ба эдгээр нь усны нөөцөд бага эрчимтэй нөлөөлөл үзүүлнэ.

Амьтны аймагт нөлөөлөх байдал

Төслийн талбай нь Э-Транс ХХК-ийн лицензийн талбайд байрлах ба уул уурхай, үйлдвэрийн үйл ажиллагаанаас тухай талбайд зэрлэг амьтад дайжиж амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдах гэх мэт нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдал

Шохойн дотоодын хэрэгцээг хангах, иргэдийг ажлын байраар хангах, улсын татвар хураамж орлогыг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй. Шохой боловсруулах үйлдвэр нь Тэвш нуур ордын уурхайн лицензийн талайд байрладаг ба нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөх шаардлага гараагүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Төв аймгийн Баянцагаан сумын нутагт хэрэгжих “Тэвш нуур” шохойн чулууны ордыг түшиглэн байгуулж буй “Шохой боловсруулах үйлдвэр” ашиглах, шохойн үйлдвэр байгуулах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” –ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Баянцемент” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОНХЯ-наас /хуучин нэрээр/ 2014 онд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Үүнд:

- ✓ Байгаль орчинд төслийн зүгээс үүсэх, үүсч болох сөрөг нөлөөллүүдийг бууруулах, урьдчилан сэргийлэх
- ✓ Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,

БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалалтын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Баянцемент” ХХК нэртэй шохой боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Зардлын хэмжээ, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давстам	Баримтлах стандарт, аргачлал
Агаар							
1	Шохой боловсруулах үйлдвэрээс гарах тоосжилт, утаа тортог, CO, SO2, NO2-ын хэмжээ ихэсч болзошгүй	Төслийн гадаах талбай, зогсоолыг цементлэн тохижуулах*	2026	1,000,000	1,000,000	2026 оны 09 сард	MNS 5342:2025
2		“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд жилд 200 ш мод тарих	200 ш мод	20,000	4,000,000	2026 оны 10-р сард	MNS 6258-2:2011 MNS 6141:2020 MNS 6140:2010 **MNS 6255:2011**
Ургамал ба амьтан							
7	Талбайн ургамлан бүрхэвч төслийн үйл ажиллагаанд өртөн нэмэгдэх	Үйлдвэрийн автозамыг засаж сайжруулж, тэмдэгжүүлэх	3ширхэг	165,000	400,000	2026 оны 09-р сард	MNS 4596:2014 **MNS 4597:2014**
Хөрсөн бүрхэвч							
8	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хөрс бохирдох	ШТМ асгарсан тохиолдолд бохирдол тархахаас сэргийлэх, зайлуулах эд хэрэгслийг байршуулах	2026	300,000	300,000	2026 оны 08 сард	
Ус							
11	Усны бохирдлоос хамгаалах	Ус ашиглуулах зөвшөөрөл авах	Жил бүр	50,000	50,000		
12		Хаягдал усны зөвшөөрөл, дүгнэлт	Улирал бүр	115,000	230,000		
Нийт					4,980,000		

4.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2026 онд тарих улирал өнгөрсөн тул 2027 онд ногоон байгууламж байгуулна.

4.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Баянцемент” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй. Археологийн дурсгал илрээгүй байна. 2026 онд МУ-ын ШУА Палеонтологийн төв байгууллага, Археологийн хүрээлэнд хүсэлт гарган Археологи, палеонтологийн дүгнэлтийг гаргуулахаар төлөвлөв.

Хүснэгт 3.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Цар хүрээ	Зардал, төг	Давтамж	Баримтлах бичиг баримт
Археологи, палентлоги судалгаа*	1.5 га (үйлдвэрийн талбай)	3,000,000	1 удаа	

**-үйл ажиллагааны зардал*

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2026онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.5. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн зардал, төгрөг

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ажлын байруудад ХАБЭА-н холбогдолтой самбар байрлуулах	300,000	8-р сард
2	Эмнэлэгийн анхны тусламжийн хангамж байршуулах	200,000	8-р сард
3	Аваар устгах төлөвлөгөө боловсруулан үйлдвэр, лабораторид байршуулах	200,000	8-р сард
4	Ажилчдыг ХАБЭА сургалтанд хамруулах*	5,200,110	9-р сард
5	Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчийн үзлэгт хамруулах*	17,100,000	10-р сард
6	Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх хүнсний бүтээгдэхүүнээр хангах*	21,375,000	Үйл ажиллагааны турш
7	Ажилчдыг тоосноос хамгаалах хэрэгсэл болон хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах*	47,239,890	Үйл ажиллагааны турш
	Нийт зардал	**700,000**	

**-Үйл ажиллагааны зардал*

4.6.Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Хяналт-шинжилгээний үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар				
Тоосжилт PM2.5, PM10 Агаар бохирдуулагч SO_2, NO_2	Шохой боловсруулах үйлдвэрийн талбай	Жилд 2 удаа	400,000.0	MNS 4585:2016 MNS 5013:2009 MNS 5014:2009
Усан орчин				
Худгийн усны шинжилгээ	Гүний худгаас	Жилд 1 удаа	200,000.0	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS13.060.50 Усны чанарын стандарт MNS0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний бохирдол,	Үйлдвэрийн талбай	Жилд 1 удаа	220,000.0	MNS5850:2019 “Хөрсний чанар. Хөрс бохирдулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ ISO15799:2003, ISO15799:2005 “Хөрсний чанар. Хөрс болон хөрсний орчны хортой үзүүлэлтүүдийн удирдамж
Төслийг хэрэгжүүлэх зардлын дүн			**820,000.0**	

4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

№	Хог хаягдлын ангилал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгах талаар ажилчдад заавар зөвөлгөө өгөх	Ажилчид		20,000	1 удаа, 8-р сард	Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдлын цэг орчмыг тогтмол цэвэрлэж арчлах, ариутгах	Төслийн талбай орчим	100,000	100,000	1 удаа, 9-р сард	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
3		Дахивар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Дахивар хог хаягдал	130,000	130,000	1 удаа, 10-р сард	
4		Энгийн хог хаягдлыг Төв аймгийн Баянцагаан сумын засаг даргатай Хог хаягдал цуглуулах, тээвэрлүүлэх үйлчилгээний гэрээ байгуулан зайлуулах	4 сар	165,000	660,000	Сар бүр	
5	Автомашинаас ялгарах аюултай	Аюултай хог хаягдлыг ялган стандартын дагуу хадгалах	Төслөөс ялгарах аюултай хог хаягдал	300,000	300,000	Үйл ажиллагааны турш	
6		Аюултай хог хаягдал тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлэх		200,000	200,000	8-р сард	
	Нийт зардал			**-**	**1,410,000**		

4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 8. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал, төг
1	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Үйлдвэрийн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	V сард	220,000

* - үйл ажиллагааны зардал

4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа			Хариуцсан албан тушаалтан
			2026 он			
			1-4р сар	5-8-р сар	9-12-р сар	
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг боловсруулж жил бүр батлуулж ажиллах	Дотоод зардаар				БО-ны мэргэжилтэн .
2	Орон нутгийн засаг захиргаа хорооны иргэдийн саналыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож ажиллах	Дотоод зардаар				БО-ны мэргэжилтэн

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

“Баянцемент” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд нийт **7,910,000** төгрөг төлөвлөв. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг 2027 оны хавар хийнэ.

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн товчоо

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үзүүлэлтүүд	Жилд /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хөтөлбөр	4,980,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	700,000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	820,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,410,000
Нийт зардал		**7,910,000**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа төгрөг 3,955,000 төгрөг байршуулна.